

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 12/370

НШУС

2011

“БЕФИНД БАЙХ МОНГОЛ СУРАГЧИЙН ХУРЛЫН ЭХЛЭН ҮҮСГЭСЭН ДАРМАЛ” ХИЙГЭЭД БЕФИН ДЭХ СЭХЭЭРСЭН МОНГОЛ СУРАГЧДЫН ҮНДЭСТНИЙ УХАМСАР

Оюун*

* Өвөр Монголын Их Сургуулийн сонин мэдээ, хэвлэлийн ажилтны салбарын эрхлэгч, профессор
Хөрвүүлсэн Л.Норовсүрэн

Түлхүүр үг: Бефин, монгол сурагчийн хурал, дармал, үндэстний ухамсар

Агуулгын товч: Бээжин их сургуулийн Номын санд хадгалагдаж буй хэмээн тэмдэглэгдсэн боловч олдохгүй байсан “Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал” нэгэнт зохиогчид олджээ. Тус сэтгүүлийг үндэстний ухамсар нь урьд өмнө гараагүй сэргэсэн “Бефинд байх монгол сурагчийн хурал”-аас дарлал мөлжлийг ханатал амсаад нэгэнт ядууран доройтохын туйлд хүрсэн монгол үндэстний доройтсон шалтгааныг эрэн гаргаж, үндэстнээ дуудан сэрээх, бүлгэмдэн нягтруулах, мандуулан хөгжүүлэх яриа хэлэлцээний багажийн хувиар эрхэлсэн байна.

1925 оноос хойш Бээжинд хүрч суралцах монгол сурагчид улмаар олширчээ. Үүнд Бээжин их сургууль, Бээжингийн багшийн их сургууль, Бээжингийн Монгол-Төвдийн сургууль зэрэг улсын эрхэлсэн сургууль болон Фу Рен, Мин Хүвэй, Цу Ен зэрэг хувийн эрхэлсэн сургуулиудад суралцаж байгаа монгол сурагчид бараг 200 гаруй болж байв. Эдгээр сурагчид сурган хүмүүжил хүртэж сэхээрэн ухаарсны

хараагаар XIII зуунд алдар нэрээ дэлхий дахинд мандуулж, нэг үе сүр хүч бүрдэн дэлгэрсэн монгол угсаатан Чин улсын хагацуулан салгаж, хэсэглэн захирах, ван гүнгийн өргөмжлөл хүртээж илбэн татах, шашин дэлгэрүүлж мунхруулан номхотгох бодлогоо 200 гаруй жилийн ноёрхлыг өнгөрөөгөөд XX зуун болж ирэхэд нэгэнт ядуу хоцронгуйн туйлд хүрч, “Үхээнц буурай ард угсааны дотор багтагдсан хорсолт байдлыг нэгэнт сэргэж мэдсэн байна. Нэн ялангуяа Чин улсын сүүлч үеэс эхэлсэн “Иргэдийг нүүлгэн хилийг бататгах” бодлого ба Иргэн улсын Засгийн газрын хэрэгжүүлсэн онцгой орон гаргах буюу муж байгуулахаар дамжин “Иргэдийг нүүлгэж газар талбин атар хагалбарлах, Монгол орны улс төрийн байгууллыг нэгмөсөн муж, сияаны байгууллаар оролцуулж, монголчуудыг улс төрийн талаар, газар орны талаар хэсэглэн салгаж үндэстнийг хайлуулах”¹ бодлогын үр дүнд “Дотоод Монголын засаг засрал нь харанхуй, эд ашиг нь эвдрэнгүй, утга соёл нь хоцронгуй, ард олны амьдралыг хамгаалахуйяа бэрх, сургаалыг хэлэлцэх газаргүй, зан ааль нь утгагэгээн бус” болсон элэг эмтрэм эмгэгээ нэлт байдалд үндэстний ухамсар нь урьд өмнө гараагүйгээр сэргэж,

“Бүгдээр бүлгэмлэн, олноор эвлэлдэж” “Бефинд байх монгол сурагчийн хурал”-ыг зохион байгуулж “Монгол угсааны утга соёлыг бадруулж, угийн байсан эрх хүчээ эгүүлэн олох”-ын төлөө “Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал”-ыг эрхэлсэн байна.

Нэг. “Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал”-ын тухай

“Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал”-ын тухай “Бүх улсын монгол хуучин номын гарчиг”² ба “Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын газар орны сонин сэтгүүлийг магадалсан гарчиг”-т “Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал” хэмээж, 1929 оны нэгдүгээр хугацаа ба 1930 оны зургадугаар хугацаа нь Бээжин их сургуулийн номын санд хадгалагдаж буй хэмээн хоёр ном тэмдэглэж, 1930 онд хэвлүүлсэн хоёрдугаар хугацаа нь Дундад улсын Ардын их сургуулийн номын санд хадгалагдаж буй гэж “Бүх улсын монгол хуучин номын гарчиг”-т бичжээ. “Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг”³-т “Бефинд байх монгол сурагчийн хуралд” хэмээж, 1929 онд хэвлэгдсэн нэгдүгээр хугацаа нь Бээжин их сургуулийн Дорно дахины хэл утга зохиолын салбарын материалын тасагт хадгалагдаж буй гэж тэмдэглэжээ.

“Өвөр Монголын хуучин сонин сэтгүүлийн магадалсан гарчиг”-т “Бефинд байх монгол сурагчийн хурлын гаргасан дарамлал” хэмээж 1930 оны нэгдүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 2 болтол гарч байсан 4-7 дугаар нь Японы Дорнод дахины бичгийн хөмрөгт хадгалагдаж, 1930 онд гарч байсан зургадугаар хугацаа нь Бээжин их сургуулийн номын санд хадгалагдаж байна гэж мэдээлж, тус сэтгүүлийн нэгдүгээр хугацаа ба хоёрдугаар хугацааг хүмүүс эдгээр газраас эрээд олохгүй тул бараг

гээгдэж орхигдсон магад гэж үзэж байжээ.

Гэтэл зохиогч ноднин хоёр удаа Бээжин их сургуулийн номын санд хүрч, дахин давтан эрж байгаад хуучин ном бичгийн дотроос тус сэтгүүлийн нэгдүгээр хугацааг завшаанаар олж аваад цахилгаан буулгавар хийж тус сэтгүүлд нийтэлсэн холбогдол бүхий мэдээ зангийг дор танилцууллаа.

Бефинд байх монгол сурагчийн хурлыг 1928 оны эцсээр “харилцаа холбоо байгуулан эрдэм шинжилгээг судлан монгол соёлыг ахиулах” зорилгоор Намхайжав (Хятад нэр нь Рен Бин Жиүн, Жин Диян Лу, Мэргэнбаатар нар Бефинд үүсгэн байгуулсан юм. Тус хурлын бүрэн эрхт байгууламж болох гүйцэтгэх хороо ба байцаах хороо тус тус 21 гишүүн ба 5 гишүүнээр бүрэлдэж, гүйцэтгэх хорооны дотор 7 хүн нь байнгын гишүүн болно. Гүйцэтгэх хорооны дотор бичээчийн тасаг, харилцах тасаг, хэвлэлийн тасаг, ерөнхий зөвлөлийн тасаг ба хянах тасаг, цэнгэлийн тасаг гэж 6 тасаг гаргажээ. Байцаах хороо нь тус хурлын хэрэг явдалд хяналт хийнэ. Тус хурлын байнгын хороог түр Бэфин дэх Монгол-Төвдийн сургуульд байгуулахаар тогтжээ.

Э нэ хурал байгуулагдсаны дараа “Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал” (сэтгүүл нь хоёрдугаар хугацаанаасаа эхлээд “монгол” хэмээн нэрийджээ)-ыг гаргажээ.

“Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал”-ыг 1929 онд монгол, хятад хоёр утгаар 17x25 см-ийн хэмжээтэй, хорголжин бараар хэвлэсэн байна. Сэтгүүлийн хавтсыг бүдүүн хөх зураасаар хүрээлж дээд, доод хоёр хэсэгт хуваажээ. Дээд хэсэгт сэтгүүлийн нэрийдлээ бичиж, доод хэсэгт асга хадны хажуу дээр нэгэн монгол хүн оцойн сууж, гэрэлт нарны доор мөнхрөн “унтжээ”. Толгой дээрээс нь “дарлал” гэсэн үсэгтэй нүсэр том чулуу унамаар байх аймшигтай байдалд нэгэн залуу “монгол” далбаа

бариад "унтсан монгол"-оо дуудан сэ- рээж байгаагаар зуржээ. Хөвөөлөм- жийн гаднах доод талд "монгол бич- гийн хорооноо дармаллавай" гэж бичжээ. Энэ хавтас хятад монгол хоёр буй. Зөвхөн хавтасны дээд хэсэг дэх сэтгүүлийн нэрийдлийг монгол, хята- даар бичсэн ба дармалласан газрыг монгол, хятадаар бичсэн ялгаатай. Өөр нь цөм адилхан юм.

Сэтгүүлийн ерөнхий найруулагчийг урьд хожид Намхайжав ба Даваадон- чир хариуцаж, Рен бин Жиүн, Жин Диян Лу, хан Жи Мин, Махсир нар найруу- лагчаар ажиллаж байжээ. Бээжинд байгаа ба Бээжинд ирсэн монгол ван, гүн, сэхээрсэн хүмүүсийн дэмжсэн мөнгө төгрөг ба хурлын гишүүдийн тушаасан хурлын сүйтгэл мөнгөөр сэтгүүлээ хугацаа бүр 1000 дэвтэр хэвлэн гаргаж, мөнгө төгрөгөөр ту- салсан ба эл хошуу чуулганы засаг яам, сургууль жич бичиг нүдэлдэг малчин, тариачинд хүргэдэг байжээ. Сэтгүүл хэзээ хэвлэл зогссон, нийт хэдэн дугаар хэвлэгдсэн нь тодорхойгүй. Зарим нь нийт 8 дугаар хэвлэгдлээ гэдэг, зарим нь нийт 12 дугаар гарсан гэдэг. Гэтэл 1930 оны 1-12 сар дотор гарч байсан 4-7 дугаар хугацаа нь Японы дорно дахины бичгийн хөмрөгт хадгалагдаж байна гэж Японы Сиюүвэ охидын сургуулийн профессор Хөхбаа- тар гуай мэдээлсэнээс үзвэл тус сэтгүүл 1930 оны 12 дугаар сар болтол гарч байсан бөгөөд адагтаа нийт 7 дугаар гарсан нь маргашгүй юм.

Уг сэтгүүлийн зорилтын тухай Намхайжавын бичсэн "Дарамлал гаргасан үгс"-д "...Энэхүү дарамлалыг

гаргасан чухам учир зорилт нь унтсан олон монголоо цочоон сэ- рээсүгэй хэмээсэнд болой. Бидний энэхүү дарамлалд эрмэлзэх нь өнө харанхуй будангуйгийн дотроос гялбалзан толбилзох гэрэл гарч, энэхүү гэрэл нь олон түмний сэтгэл зүрхийг гэрэлтүүлж аливаа Дотоод Монголын газар цөм гэрэлтэн тусч ... нимгэн мөлсөнөө амьдрах олноо удирдан, энх амгалан- гийн орноо оршуулах бөгөөд, очир тамын ёроолд байх олноо өргөн гар-

гаж, аливаа манд гаслан зовлон болох зүйлийг цөм устгаж, эрх хүчин өнө бат жаргалангийн хү- рээлэн байгуулж, олноор амаржи- хад амой" гэжээ. Сэтгүүлийн мон- гол нийтлэлийг ажиглавал, гол- дуу шүүмж өгүү- лэл ба үлгэр уран зохиолоор бүрэл- дэж, Намхайжа- вын "Дарамлал гаргасан үгс" ба "Ертөнцийн их төлөв", Лавын

"Дэвтрийн тэргүүнээ дурдсан үгс", Кен Жэй Мин-гийн "Бефинд байх монгол сурагчийн хурлаас үүдэж гаргасан сэтгүүл дарамлалын дурсгал", Бөх- Үндэсийн "Монголдоо сануулах үг", Хас-Очирын "Монгол угсаагаа дахин бататгамой", Кен Бин Жиүн-гийн "Монголын зохистой мандуулах явдал хөрөнгө", Кен Жэй Мэн-гийн "Монгол залуусын үүрвээс зохих үүрэг", Махши- рын "Монголын байдал" ба "Нэгэн ардын угсаатны мөхөх устах учир гараа", "Одоо мань угсааны мөхөхийг шүүмжлэх нь" гэх мэтийн Монголд холбогдох хэрэг учрын тухай шүүмжлэн өгүүлж, Монголын засаг засалтыг хэрхэн сайжруулах, Монголын аж ахуйг хэрхэн хөгжүүлэх, Монголын утга

«

"Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал" сэтгүүлийн дээд хэсэгт сэтгүүлийн нэрийдлээ бичиж, доод хэсэгт асга хадны хажуу дээр нэгэн монгол хүн оцойн сууж, гэрэлт нарны доор мөнхрөн "унтжээ". Толгой дээрээс нь "дарлал" гэсэн үсэгтэй нүсэр том чулуу унамаар байх аймшигтай байдалд нэгэн залуу "монгол" далбаа бариад "унтсан монгол"-оо дуудан сэ- рээж байгаагаар зуржээ.

»

соёлыг хэрхэн дэгжрүүлэх, Монголын эрх ашгийг хэрхэн хамгаалах, Монголын сурган хүмүүжлийг хэрхэн дэлгэрүүлэх асуудалд чиглэгджээ. Дурдуштай нь сэтгүүлд нийтэлсэн Си фун Сан, Тэмүрдэйн "Хар аалз, хар ялааны үлгэр", Махширын "Хөхөө, шаазгай хоёрын битүү үгст үлгэр" гэх мэтийн үлгэр уран зохиол ч тухайн үеийн Монголын асуудалд хандуулан их хятадчилах үзлийн үндэстний дарлалыг хабулигаар илтгэсэн байдаг.

Хоёр. Бефин дэх сэнхэрсэн монгол сурагчдын үндэстний ухамсар

Бефинд байх монгол сурагчийн хурлын ухааран сэнхэрсэн гишүүд "Очир тамын доор, нимгэн мөсний дээр амьдарч бүхий гаслантай, түгшүүртэй" монгол тоотноо дуудан сэрээж, "Хэдэн зуун түмэн ард олноо эрх тэгшийн оронд хүргүүлж, бүрэн ардын засаг засралыг олгуулах"-ын төлөө, "Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал"-ыг эрхлэн монгол үндэстний доройтон буурсан шалтгааныг задлан шинжилж, үндэстнээ хүчирхэгжүүлэх арга замыг эрэлхийлэн, ард угсаагаа мандуулах тухай сурталчлан ухуулсан байна. Энэхүү ажиллагаа бол Бефин дэх сэнхэрсэн монгол сурагчдын үндэстний ухамсрын бодитой илрэл болох юм.

1. Монголын доройтсон шалтгааныг эрэлхийлсэн нь. Сэнхэрсэн монголчууд үндэстнийхээ доройтон буурсныг Чин улсын Монголд явуулж байсан бодлогоос шалтгаан эрсэн мөртөө бас Иргэн улсын хоёр үеийн засгийн газрын Монголд авч байсан бодлогоос ч учир шалтгааныг эрж, Чин улсын засгийн газар хүчирхэг Монголыг доройтуулан бууруулсан юм бол, Иргэн улсын засгийн газар монголчуудыг нэгмөсөн мөхөөх замд оруулсан юм гэж үзсэн байна. "Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал"-ын "Монголдоо сануулах үг"-д "Манай Монголын буурай болсон учир нь хэдэн зүйл буй. Олон бүгдээр эв найрамдуу-

гүй нь нэг, сургаал соёл хүнээс хожидсон нь хоёр, сүсэг бишрэлд төөрөгдсөн нь гурав ... урьд Манж төрийн үед анги бүлэг хуваалдан, аймаг угсаагаа санал бодол өтгөн болгоод, өөр хошууны хүн цагаагчин хэмээн нэртдэн хар хятадыг хүрэхгүйгээр үзэх, нэгэн хошуу гачигдал чухалд тохиолдвоос өөр олон хошууд өчүүхэн ч туслахгүй бөгөөд заримууд нь хажуудаас ханал болон сууж, эс бөгөөс гал дээр тос дусааж хэргийг ихэтгэх нь даруй монгол хүний найзам найрамдахгүйн үлгэр болой. Сургаал соёл хэмээгч ухаан оюуны уг үндэс тул сургаалгүй бөгөөс утга оюун нээгдэхгүй, утга оюун нээгдэхгүй бөгөөс би билэг мунхран балартаж, үзэл мэдэл болхи гүехэн болон улс гүрэн тогтнох сөнөх, аймаг угсааны мандах буурах, ард олны амар зүдүүр, орон нутгийн төвшин түгшүүрийг огт анхаарахгүй өөр аймгийн хорлох, эзэрхэг улсын дарлах, уул голын өнгө хувирах, эрх ашгийн хасагдахыг огт мэдэхгүй, өдөр бүр амгалан жаргаланг эгээрч өнгө дарсанд цэнгэлдэхийг эрхэм болгомой... Манай монгол хүний сүсэглэн бишрэх нь бурхан шашин. Гэвч бурханы гол зорилт нь элбэрэн энэрэхгүйгээр үл алахыг эрхэмлэснээс алив зүйлийн хэргийг цөм буруу даатгаваас даруй сэтгэлчлэн бүтээж өгмүй хэмээн соёрхсонгүй болой.

Харин манай монгол хүн буруу сүсэглэж алив зүйлийн хэргийг цөм бурханаа даатган залбирч өөрөө чармайхгүй, ганц амаа ангайн тэнгэрийг харж нэгэн үмх будаа өгмүй хэмээн санаад тариалан төмсийг тарихгүй, тарьсанаа талчдан хаяад хамаарахгүй, адуу малаа зээр талбин, ажил амьдралаа анхаарахгүй гагцхүү заяаны сайн мууд хэлэлцмүй" гэж Монголын доройтсон шалтгааныг Чин улсын Монголд явуулсан бодлогоос болж, бүлгэмдэл нягтралгүй, утга соёл хоцронгүй, шашин суртахуунд баллагдсан хэмээн үзжээ.

"Бефинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал"-ын

“Нэгэн ардын угсаатны мөхөж устахын учир гараа”-д “Түүний (ардын угсаатан) устаж сөнөхийн учир гараа нь гурван зүйлийн хөнөөлөөс гарахгүй ... даруй аяндаа улирахын хүчин, засаг засралын хүчин, эд ашгийн хүчин мөн ... Манай монгол угсаатан болбаас энэхүү гурван зүйлийн хөнөөлийг давхарлан амсаж буй ... даруй хятад угсаатны энэхүү гурван зүйлээр манай Монголыг хяхан мөлжиж ахуй нь чухам хүнд нь болой ... Дотоодын үхээнц буурай угсаатныг мөнхүү энэ гурван зүйлээр хөнөөн дарлаж, элдвийн уран үгээр олон монголыг мэхлэн, өөр угсаатныг цөм өөрийн угсаандаа хувилган дагуулж авсугай гэж буй ... Энэ нь манай Монголын дотоодоос үүсгэсэн аяндаа улирахын хүчийг шууд амсаж ахуй мөхөөл болой ... Дотоод Монголын эл хошуунаа цөм саян байгуулж, монгол хүний засаг засралын эрхийг цөм булаан авч, хоосоор хэрэггүй ван гүнгийн цолыг өгч, чухам мэдэл эрхийг цөм саяны гарт оруулж, Хятадаа хамгаалан, Монголыг дарлаж байхын учир ... Энэ нь олон монгол бүгдээрийн нүдээр үзэж, биеэр амсаж байх засаг засралын хүчээр дарлах хөнөөл биш үү ... Манай монгол угаас үйлдвэрийн хөрөнгө, арилжааны хөрөнгө цөм үгүйн тул аливаа хэрэгслийн зүйлийг цөм хүнээр эрмэлзэх бөгөөд холжин хойхор худалдаачны урин аргад оногдож, ашиг зоосоо учиргүйгээр хожигдох нь аль олон буй.

Монгол газрын эл зүйлийн гаралт нь элбэг гэвч олонхийн эрх хүний гарт орж, өөрөө эзэн болж чадахгүй ... энэ нь эд ашгийн хүчээр биднийг хөнөөхийн их төлөв болой” гэж нэг үндэстний устаж мөхөхийн гурван шалтгаан хувьслын хүч (шилдэг нь үлдээж, шаар нь орхигдох), улс төрийн хүчин ба аж ахуйн хүчийг заан гаргаж, энэ гурван талаар цөм хөнөөл амссан монгол үндэстний элэг эмтрэм хувь заяаг тоочиж, Иргэн улсын Монгол оронд атар хагалбарын муж байгуулж “Засаг засрал”-ын эрхийг булаасныг шүүмжилсэн байна.

Тус сэтгүүлийн “Монголын зохиотойёо мандуулах явдал хөрөнгө”-д “Манай монгол угсаатан энэ өдөр болоод нэгэнт бүдрээд дахин болохуйяа бэрх болжээ. Эдүгээ болохадна унтран суугаад, утга соёл нь мөчид болж, ухаантай эрдэмтэн ховор болж, эл явдал цөм дэгжихгүй болсон бөгөөд орон газар энэ агуу өргөн дээр аман тоо нь өчүүхэн цөөхөн болсноор өөр өөр угсаатны халдан дарлах сэтгэлийг өдөөн босгож, эл эзэрхэгтэн нарын дарлан мөлжихийн зовлонг амсаж амой. Энэхүү учрыг хэдэн зурвас татлан гаргаж олноо өргөн сонсгосугай” хэмээж, Иргэний засгийн газраас Монгол оронд элдвийн аргаар малын бэлчээрийг хагалж газар нутгийг нь булааснаас монгол хүний амьдрал өдөр ирэхүйеэ хүчин бэрх болсон, цааз хууль тэгшгүй болж, Хятад Монголын хэрэг заргад монгол хүн ёс байгаад ёсоо олохгүй, нутаг усаа хүчирлэгдэн булаагдаж, хөрөнгөө алдаж элгэн садан хагацсан байдал, арилжаа худалдааны дунд хятадын зусар худалдаачинд мэхлэгдэж байх зэргийг дурдаад “Одоо удалгүй монгол угсаатан ертөнцөд үлдэхгүй болох магад” гэж эмгэнэжээ.

Мөн тус сэтгүүлд нийтэлсэн “Монгол угсаатнаа яахин бататгамай” гэдэгт: “Эдүгээ юунд ийм зөөлөн буурай угсаатан болж бусдад дарлагдан байх ажээ. Үүнийг эргэцүүлэн бодвоос нэгд: эрдэм соёл балрагдаж, уг үндэстний үсэг хэлээ умартсан нь олон болжухай, хоёрт: эрх хүчээ алдаж, олон ардын санал зориг нь эс нийлмөй, гутгаарт: орон нутгаа алдаж, аж төрөн амьдрах газаргүй болсноос ийм болжухай. Тиймийн тул эдүгээ цагийн хувьсгалд эртхэнээс урагш давшин монгол угсаагаа мандуулбаас бараг амжихгүйд хүрчээ” гэж үндэстний доройтсон шалтгааныг утга соёл ба газар нутгаа алдсанаас болсон хэмээн үзэж, хувьсгалын аргаар монголоо мандуулахыг дурдажээ.

2. Монголоо мандуулах арга замыг ухуулсан нь

“Бэфинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал”-ыг шүүж үзвэл бүлгэмдэн нягтарч бүлгэм болон бүрэлдэх, утга соёлоо дээшлүүлэн ардын мэдлийг нээх, сурган хүмүүжлийг дөхмөлжүүлэн үндэстнээ мандуулах, мунхаг бишрэлийг арилган лам хуврагийг хязгаарлах, үнэн үйлсийг эрхэмлэж, аж ахуйгаа хөгжүүлэх, ард олон нягтран “өөрөө чармайн байгуулах” зэрэг арга замыг дурдан ухуулж, монгол ард олны үндэстнээ мандуулахыг өөрийн үүрэг болгон урагшаа чармайн тэмцэхийг уриалсан байна.

Сэтгүүлийн “Монголдоо сануулах үг”-д: “Энэ өдөр монгол угсаагаа дэгжүүлсүгэй хэмээхүл эрхгүй монгол ард бүгдээр хэн алины хязгаар ялгаврыг хаяж, энэ тэр хэмээн хуваахгүй, санаагаа нэгтгэн, хүчээ нийлүүлэн зовлон зүдлийг хамтатган, үхэх төрөхийг цугаар болгон олонх сургууль байгуулан олон улсын шинэ сургаалыг нөхөн авчирч монгол бичгээр орчуулан, олон ардыг цөм монгол бичигт боловсруулан аймаг угсааны бодлыг дэгжүүлэн, газар орны засаг засралыг шинэтгэн сайжруулж, үйл заяа хэмээхийг халж, ямар явдлыг ч цөм хүний хүчээр бүтээж болмой хэмээн бодож, урагш хүчлэн чармайваас аймаг угсаа хэрхэн үл мандах ажээ” гэж Монголоо мандуулахад бүлгэмдэн тэмцэх, сурган хүмүүжлийг эрхэмлэх, засаг засалтаа шинэчлэх хэрэгтэй гэж үзжээ.

“Монголын зохистойёо мандуулах явдал хөрөнгө”-д: “Энэ өдрийн арга нь хатуу зоригоор халан шинэтгэж, хүч чинээгээр хэвлэн засваас зохимой, тэрхүү сургаал хүмүүжил хэмээх, цэргийн үйл хэмээх, засаг засрал хэмээх, сүрэг бэлчээр хэмээх, ажил хөрөнгө хэмээх, ажил амьдарлага хэмээх, ардын хамгаалал хэмээх, хөхүүн зан ааль хэмээх зэргийн үйлсийг дэс дараалан үүсгэн одож, үнэмшлэн үйлдвээс ... манай монгол үндэстний хожмын буян болж болмой.

Сургаал хүмүүжил хэмээгч зуун зүйлийн үндэс болох бөгөөд суртал шийдвэр хэмээгч улсыг чийрэг болгохын уг болой ... Иймийн тул хурдхан элбэг арвин сургууль байгуулж, эрдэмтэн оюутныг олонт хүмүүжүүлэн гаргаваас зохимой” гэж дурдаад нийтийн сургаал хүмүүжил, ажил хөрөнгийн сургаал хүмүүжил, багшийн дүрэмт сургууль хүмүүжил, тусгай ангийн сургаал хүмүүжлийг хөгжүүлэх арга замыг дурдсан байна.

Ерөнхийлбэл: ХХ зууны хорь, гучаад онд шинэ маягийн сурган хүмүүжил хүртсэн монгол сурагчид ухаарч сэхээрсний гараагаар үндэстнийхээ ядуурч хоцорсон байдал болон Иргэн улсын дарлал мөлжлийг нүдээрээ үзэж, чихээрээ сонссоны хувьд үндэстний ухамсар нь урьд өмнө гараагүй сэргэж, сонин сэтгүүл эрхлэхээр дамжуулан үндэстнээ мандуулах үзэлтэй хүчтэй ухуулсан байна.

Ишлэл

1. *Алтандалай*. 2009. Монголын орчин үеийн түүх судлал. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 71 дэх тал.
2. 1979. Бүх улсын монгол хуучин номын гарчиг. Нэймэн муж орны монгол хэл бичгийн ажлын хамжилцах дугуйлангийн албан гэрээс хэвлүүлэв. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
3. 1999. Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг. Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг”-ийн найруулах зөвлөл найруулав. Бээжин номын сан хэвлэлийн хороо.

Резюме

В данной статье автор излагает специфику и публикационную политику журнала “Газета, издаваемая собранием монгольских учащихся в Беофине”. Всего вышло шесть номеров этого журнала, некоторые из которых считались утерянными, но найденными автором в библиотеке Пекинского университета. Журнал примечателен тем, что издавалась патриотически настроенной монгольской интеллигенцией.